

ЭМТ - ийн 2017 оны үйл ажиллагаанд хэрэглэгчийн өгсөн
үнэлгээний дагуу хийсэн ажлын тайлан

50 иргэнээс авсан байгууллагын үйл ажиллагааны үнэлгээ, ажилчдын харьцаа соёл, үйлчилгээний чанар түргэн шуурхай байдал, мэдээллийг цаг тухайд нь хүргэх асуудал зэрэгт өгсөн үнэлгээг байгууллагын нийт ажилчдын хурлаар танилцуулж гарсан санал хүсэлтийн дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

1. Зарим эм олддоггүй энэ асуудлыг эмийн сангийн хэрлэгч Д.Мөнхцэцэгт анхааруулж эмийн хангалтыг сайжруулах, эм татан авалтыг нэмэгдүүлэх талаар үүрэг даалгавар өглөө.
2. Багийн эмч нар хэвтрийн хүнд өвчтнийг 7 хоног бүр эргэж үзэж байхаар шийдвэрлэв.
3. 2017 оныг **“Эмч эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, хариуцлагыг дээшлүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэн бүрт чанартай хүргэе”** жил болгон зарласантай холбогдуулан бүх ажилчидтай ёс зүйн гэрээ байгуулан ажиллаж байна.
4. Эмнэлгийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй үзүүлэх стандартыг чанд баримтлах залуу боловсон хүчний мэдлэг чадварыг дээшлүүлэх дадлагажуулах чадавхижуулах чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгуулж байна. Үүнд:
 - Стресс ба үйлчлүүлэгчдэд чиглэсэн тусламж үйлчилгээ
 - Гэмтэл сэхээн амьдруулах яаралтай тусламжийн сургалт
 - Зүрх судасны өвчний үед хийх дасгал хөдөлгөөн
 - ХӨЦМ сургалтуудад хамруулсан. .

Төрийн ба төрийн бус байгууллагатай холбоотой хамтран ажиллах уралдаан тэмцээн зохион байгуулах хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор ТҮ зэрэглэлийн ажилчдын дунд 14 хоногийн аян зохион байгуулсан. Төрийн байгууллагын үйлчилгээний 40 ажилчдын дунд “Зөв хооллолт, дасгал хөдөлгөөн “ эрүүл мэндийн сургалт зохион байгуулж, дараа нь АХА тэмцээн зохиож тамгийн газрын бичиг хэргийн ажилтан М.Баярмаа тэргүүн байр эзэлж, Эрүүл мэндийн төвийн үйлчлэгч Т.Ариунтуяа дэд байранд шалгарсан.

Төрийн үйлчилгээний 38 албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулж 7 хүнийг хяналтанд авч эрүүл мэндийн зөвлөгөө өгсөн.

Гар бөмбөгийн тэмцээнд 6 багийн 48 хүн хамрагдаж 1 дүгээр байранд М.Цэвгэдорж ахлагчтай баг, хоёрдугаар байранд Э.Мөнхжаргал, гуравдугаар байранд Ш.Үйтүмэн ахлагчтай багууд шалгарсан.

Удирдамжийн дагуу соёлын төвд үйлчигээний ажилчдын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж байгууллагуудын ирүүлсэн ажлын тайлан болон шинээр хийсэн ажлыг танилцуулсан. /Байгууллагуудын ажлын тайланг хавсаргав/ Идэвх санаачлагатай ажилласан дунд сургуулийн хамт олон тэргүүн байранд шалгарч дурсгалын цом хадгалуулав.

Дараа жил Төрийн үйлчилгээний ажиллагсдын өдрийг цэцэрлэгийн хамт олон зохион байгуулахаар боллоо.





5. Амбулаториор багийн эмч нар, эмчлэгч эмч нар ажиллаж байгаа учир хүлээгдэл чирэгдэл гарахгүй байгаа гэж үзэж байна. Иргэд баг багийнхаа эмч нарт үзүүлж эмчилгээ оношлогоо хийлгэж шаардлагатай тохиолдолд эрхлэгч эмч үзлэг хийнэ. Мөн хүнд өвчтөн яаралтай дуудлаганд эрүүл мэндийн төвийн дарга хуваарь харгалзахгүй үйлчилнэ.
6. Эмнэлгийн удирдлагад ирүүлсэн 1 иргэний өргөдлийг шийдвэрлэж хобогдох ажилтанд цалингийн арга хэмжээ авсан.
7. 11 сард байгууллагын 16 ажилчдаас байгууллагын үйл ажиллагаа болон цаашид хийх ажил, ажил үүргээ гүйцэтгэх үед тулгамдаж байгаа асуудлаар санал авахад ямар нэг гомдол санал гараагүй.